

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/45/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Shinjlenmagadlahui
ezshaudit.mn
Улаанбаатар хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089, 99023682
Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn
Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит
ХХК
Утас: 99197346, 88114867 Цахим хаяг:
Shinjlenmagadlahui.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Б.ОРГИЛ
ТАНАА**

2025.02.25 № 101

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 73.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 2.4 хувийг хангамж бараа материалын зардал тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

4525020132

Дархан-Уул аймгийн Захирагчийн алба нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 93.27 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,783,280.00</u>	<u>46,831,600.00</u>
33	Авлага	-	44,623,320.00
335	Бусад авлага	-	44,623,320.00
3351	Байгууллагаас авах авлага	-	44,623,320.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,783,680.00	2,208,280.00
354	Хангамжийн материал	1,783,680.00	2,208,280.00
35470	Бусад хангамжийн материал	1,783,680.00	2,208,280.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,735,371,859.15</u>	<u>3,666,130,283.61</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,666,087,392.81	3,666,130,283.61
392	Биет хөрөнгө	12,775,392.81	12,818,283.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,916,300.00	33,871,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,515,925.09)	(25,535,150.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,267,270.00	12,501,070.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,892,252.10)	(8,018,736.39)
393	Биет бус хөрөнгө	3,653,312,000.00	3,653,312,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,653,312,000.00	3,653,312,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,667,871,072.81</u>	<u>3,712,961,883.61</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,667,871,072.81</u>	<u>3,712,961,883.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,667,871,072.81	3,712,961,883.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,673,272,955.00	3,673,272,955.00
512	Хуримтлагдсан үр дүн	(5,746,025.19)	39,344,785.61
51210	Өмнөх үеийн үр дүн	62,118,041.15	(5,746,025.19)
51220	Тайлант үеийн үр дүн	(67,864,066.34)	45,090,810.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	344,143.00	344,143.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,667,871,072.81</u>	<u>3,712,961,883.61</u>

ХТ05430 @ 9022899

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	847,595,592.00	816,802,108.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	847,595,592.00	816,802,108.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	614,496,492.00	421,002,108.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	614,496,492.00	421,002,108.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	233,099,100.00	395,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,099,100.00	395,800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	848,709,658.34	771,711,297.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	848,709,658.34	771,711,297.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	823,508,472.43	645,116,729.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,154,167.00	263,619,630.00
210101	Үндсэн цалин	97,029,655.00	135,467,292.00
210102	Нэмэгдэл	56,248,591.00	97,057,538.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,680,000.00	13,690,000.00
210104	Урамшуулал	19,195,921.00	17,404,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,683,689.91	32,194,176.06
210201	Тэтгэврийн даатгал	15,018,158.93	22,578,977.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,791,541.67	2,656,346.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,433,233.33	1,328,175.18
210204	Ажилгүйдлийн даатгал	312,794.19	1,126,134.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,127,961.79	4,504,542.28
2104	Хангамж, бараа материалын зардал	8,208,820.18	9,406,696.62
210401	Бичиг хэрэг	1,237,100.00	1,986,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,030,000.00	5,470,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,074,520.18	1,029,896.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	867,200.00	920,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
210604	Урсгал засвар	-	-
2107	Томилолт, зочны зардал	536,000.00	1,284,000.00
210702	Дотоод албан томилолт	536,000.00	1,284,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	608,391,329.00	257,265,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	595,519,393.00	244,103,782.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	902,000.00	902,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,010,000.00	1,300,000.00
210807	Газрын төлбөр	10,959,936.00	10,959,936.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,534,466.34	81,346,509.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,534,466.34	75,200,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,534,466.34	6,145,709.20


213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,201,185.91	126,594,567.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,417,500.00	40,933,631.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,417,500.00	3,417,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	38,033,631.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,900,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,783,685.91	85,660,936.32
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,783,685.91	85,660,936.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,114,066.34)	45,090,810.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	66,750,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	66,750,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(66,750,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(67,864,066.34)	45,090,810.80



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	847,595,592.00	816,802,108.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	847,595,592.00	816,802,108.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	614,496,492.00	421,002,108.00	
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	614,496,492.00	421,002,108.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	233,099,100.00	395,800,000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,099,100.00	395,800,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	844,595,592.00	810,613,508.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	844,595,592.00	810,613,508.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,394,406.09	639,395,620.68	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,944,222.00	263,619,630.00	
210101	Үндсэн цалин	96,842,674.00	114,638,309.00	
210102	Нэмэгдэл	56,045,782.00	117,886,521.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,859,845.00	13,690,000.00	
210104	Урамшуулал	19,195,921.00	17,404,800.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,893,634.91	32,194,176.06	
210201	Тэтгэврийн даатгал	15,228,103.93	22,578,977.58	
210202	Тэтгэмжийн даатгал	1,791,541.67	2,656,350.30	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,433,233.33	1,408,466.63	
210204	Ажилгүйдлийн даатгал	312,796.44	1,045,843.27	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,127,959.54	4,504,538.28	
2104	Хангамж, бараа материалын зардал	8,389,220.18	9,531,296.62	
210401	Бичиг хэрэг	1,237,100.00	1,789,400.00	
210402	Тээвэр, шатахуун	5,030,000.00	5,470,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,074,520.18	1,029,896.62	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,047,600.00	1,242,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	
210604	Урсгал засвар	-	-	
2107	Томилолт, зочны зардал	536,000.00	1,284,000.00	
210701	Гадаад албан томилолт	-	-	
210702	Дотоод албан томилолт	536,000.00	1,284,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	609,631,329.00	302,189,038.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	596,759,393.00	289,027,102.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	902,000.00	902,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,010,000.00	1,300,000.00	
210807	Газрын төлбөр	10,959,936.00	10,959,936.00	

2109	Бараа үйлчилгээний бусад зардал		75,200,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		75,200,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,201,185.91	171,217,887.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,417,500.00	40,933,631.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,417,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	38,033,631.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,900,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,783,685.91	130,284,256.32
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,783,685.91	130,284,256.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,000,000.00	6,188,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,000,000.00	6,188,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000,000.00	6,188,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	6,188,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,000,000.00	6,188,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,000,000.00)	(6,188,600.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	62,118,041.15	3,735,735,139.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	62,118,041.15	3,735,735,139.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(67,864,066.34)	(67,864,066.34)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	(5,746,025.19)	3,667,871,072.81
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	(5,746,025.19)	3,667,871,072.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	(5,746,025.19)	3,667,871,072.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	45,090,810.80	45,090,810.80
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,673,272,955.00	344,143.00	39,344,785.61	3,712,961,883.61




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	403,008,700.00	390,583,269.68	(12,425,430.32)	96.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,008,700.00	390,583,269.68	(12,425,430.32)	96.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	362,074,700.00	349,649,638.68	(12,425,061.32)	96.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,701,600.00	263,619,630.00	(10,081,970.00)	96.3
210101	Үндсэн цалин	118,753,800.00	114,638,309.00	(4,115,491.00)	96.5
210102	Нэмэгдэл	129,874,000.00	117,886,521.00	(11,987,479.00)	90.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,240,000.00	13,690,000.00	4,450,000.00	148.1
210104	Урамшуулал	15,833,800.00	17,404,800.00	1,571,000.00	109.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,212,600.00	32,194,176.06	(2,018,423.94)	94.1
210201	Тэтгэврийн даатгал	23,264,600.00	22,578,977.58	(685,622.42)	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,737,000.00	2,656,350.30	(80,649.70)	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,189,600.00	1,408,466.63	(781,133.37)	64.3
210204	Ажилгүйдлийн даатгал	547,400.00	1,045,843.27	498,443.27	191.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,474,000.00	4,504,538.28	(969,461.72)	82.3
2104	Хангамж, бараа материалын зардал	9,542,500.00	9,531,296.62	(11,203.38)	99.9
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	1,789,400.00	489,400.00	137.6
210402	Тээвэр, шатахуун	5,477,500.00	5,470,000.00	(7,500.00)	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,865,000.00	1,029,896.62	(835,103.38)	55.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900,000.00	1,242,000.00	342,000.00	138.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,250,000.00	6,188,600.00	(61,400.00)	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	2,954,800.00	(45,200.00)	98.4
210602	Тавилга	3,250,000.00	3,233,800.00	(16,200.00)	99.5
2107	Томиллолт, зочны зардал	1,496,000.00	1,284,000.00	(212,000.00)	85.8
210702	Дотоод албан томиллолт	1,496,000.00	1,284,000.00	(212,000.00)	85.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,872,000.00	18,831,936.00	(40,064.00)	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,670,000.00	5,670,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	902,000.00	902,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,300,000.00	1,300,000.00	-	100.0

210807	Газрын төлбөр	11,000,000.00	10,959,936.00	40,064.00	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	18,000,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	18,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,934,000.00	40,933,631.00	(369.00)	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,934,000.00	40,933,631.00	(369.00)	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,034,000.00	38,033,631.00	(369.00)	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,900,000.00	2,900,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	403,008,700.00	390,583,269.68	(12,425,430.32)	96.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	403,008,700.00	390,583,269.68	(12,425,430.32)	96.9
132001	Орон нутгийн төсвөөс	403,008,700.00	390,583,269.68	(12,425,430.32)	96.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7.00	6.00	-	85.7
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	5.00	(1)	83.3
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	421.002.108.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	421.002.108.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	421.002.108.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	283.357.102.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	283.357.102.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	57,200,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	57,200,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	80,444,206.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	421,002,108.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	421,002,108.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	421,002,108.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын алба нь "Төр,иргэн,аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын ажиллагаа бүтээлч оролцоонд тулгуурлах замаар иргэдийн ая тухтай амьдрах таатай орчин бүрдүүлэх нь албаны эрхэм зорилгоо болгоно" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагаандаа дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Оролцоонд суурилсан сайн засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх
- Хүн амын эрүүл, аюулгүй амьдрах цогц үйлчилгээг хангах
- Монгол улсын засгийн газрын болон аймгийн Засаг даргын бодлого, үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр тогтмол хангах

Үйл ажиллагааны чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлага, санхүүгийн
- Дэд бүтцийн
- Тохижилт үйлчилгээ
- Ногоон байгууламж
- Хог хаягдлын

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон: Үүнд:

- Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан
- Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэн
- Төрийн албаны тухай хуулийн “57.17.Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно” гэсэн заалт нэмэгдэж орсон.
- Монгол улсын Сангийн сайдын 2024 оны А/52 тоот тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсөвт байгууллагын баримт бичгийг 2020 онд Ph.D МУИС-ийн Бизнесийн сургуулийн НББ-ийн дэд профессор, МНБ Д.Нямаа, мэргэшсэн нягтлан бодогч Ш.Отгон нарын боловсруулсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,090.8 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	1,783.7	2,208.3	424.6
Үндсэн хөрөнгө	3,666,087.4	3,666,130.2	42,8
Нийт хөрөнгө	3,667,871.1	3,712,961.9	45,090.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,667,871.1	3,712,961.9	45,090,8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,667,871.1	3,712,961.9	45,090.8

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 1,783.7 мянган төгрөг байснаас төсвийн хөрөнгөөр 8,801,4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 8,376.8 мянган төгрөгийг зарцуулж бараа материалын үлдэгдэл 2,208.3 мянган төгрөг буюу өмнөх оноос 424.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,666,087.4 мянган төгрөг байснаас оны эцэст 3,666,130.3 мянган төгрөг болж нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 6,188.6 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс орлогыг 390,583.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 390,583.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор 2024 оны төсвийг 384,648.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж 2024 оны төсвийг 403,008.7 мянган төгрөг буюу 18,360.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Энэ нь Аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн байгууламжийн /нийтийн орон сууцны цахилгаан шат/ ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, байнгын ажиллагаатай байлгахтай холбоотойгоор нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 70106/-ийн 3 арга хэмжээ / үндсэн үйл ажиллагаа 80101, мэдээлэл сурталчилгааны зардал 80205, ажил олгоогоос олгох тэтгэмж 80802/-г санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 395,800.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 390,583.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 390,583.3 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 10,081.9 мянга, НДШ-ийн зардлаас 2,018.4 мянга /ажлаас чөлөөлөгдсөн 1 албан хаагчийн цалин, НДШ хэмнэгдсэн/, хангамж бараа материалын зардлаас 11.2 мянга, эд хогшил, урсгал засварын зардлаас 61,4 мянган төгрөг, албан томилолтын зардлаас 212,0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардлаас 40,0 мянган төгрөгийг тус тус хэмнэж 5,216.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр					
1	80101 Цалин хөлс, нэмэгдэл	273,701.6	263,619.6	10,081.9	96.3%
2	80101 НДШ ажил олгогч	34,212.6	32,194.2	2,018.4	94.1%
3	80101 Хангамж, бараа материал	9,542.5	9,531.3	11,2	99.8%
4	80101 Эд хогшил, урсгал засвар	6,250.0	6,188.6	61,4	99,0%
5	80101 Томилолт, зочны зардал	1,496.0	1,284.0	212,0	85.3%
6	80101 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	18,872.0	18,831.9	40,0	99.7%
7	80101 Бараа үйлчилгээний бусад зардал	18,000.0	18,000.0	-	100%
8	80101 Бусад урсгал шилжүүлэг	40,934.0	40,933.6	369.0	99.9%
	Нийт дүн	403,008.7	390,583.2	12,425,4	96,9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад насны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 -д заасны дагуу “Ахмадын сан” байгуулаагүй байна.

2024 онд орон тоо 7 төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 6 оронтой ажилласан байна. Шилэн дансны тухай хуулийн нийт 171 мэдээ мэдээлэхээс 170 мэдээлэл хугацаанд нь мэдээллэсэн. Хугацаа хоцорсон 1 мэдээ мэдээлэсэн байна. Худалдан авах ажиллагаагаар бараа ажил үйлчилгээний 8 зардалд 20,212.5 мянган төгрөг батлагдсанаас 8 бараа ажил үйлчилгээний 19,456.1 мянган төгрөгийн шууд худалдан авалтаар зохион байгуулсан байна. Бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ болон Бараа үйлчилгээний бусад зардалд нийт 94,072.8 мянган төгрөг батлагдсанаас 94,032.7 мянган төгрөг буюу 99,9 хувийн гүйцэтгэлтэй байна

3.5.3 Нэмэлт төсөв

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаас 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01-А/245 , 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01-А/210, 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01-А/194 тоот захирамжаар эрх шилжүүлэн хэрэгжүүлэх “Нийтийн орон сууцны засвар” төслийн хүрээнд НЗОС-ны дээвэр, сантехникийн засвар/иргэдийн оролцоотой/-ын ажлын төсөл хөтөлбөр, Нийтийн эзэмшлийн зам талбайн нойтон цэвэрлэгэнд ашиглах тоног төхөөрөмж авах, “ICE BOX” төслийн хөргөлтийн төхөөрөмж байрлуулах зардал нийт 238,584,5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар шилжүүлэн хэрэгжүүлсэн.

“Нийтийн орон сууцны засвар” төслийн төсөв 500,000.0 мянган төгрөгөөс гүйцэтгэлээр авсан 289,459.4 мянган төгрөгийн 210,133.7 мянган төгрөгийг төсөл хөтөлбөрийг 6 аж ахуйн нэгж, 1 иргэнтэй шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна. Аймгийн хэмжээнд нийт 9 байрны 11 орцны дээвэр болон 13 байрны 20 орцны зоорийн давхрын инженерийн шугам сүлжээг хэсэгчлэн засварласан байна.

Мөн аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө /захирамж №01-А/50, №01-А/510/-өөр нийт 57,350.0 мянган төгрөгөөр Дархан сумын нутаг дэвсгэр дээрх авто зам, нийтийн эзэмшлийн талбайн цас мөсийг цэвэрлэх, хальтиргаа гулгааг арилгах бодис авах, Дархан сумын гэр хорооллын Эко жорлонтой айлуудын бохирыг соруулах ажлын зардлыг гаргаж хэрэгжүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн 317,778.8 мянган төгрөг, засаг даргын нөөц хөрөнгийн 58,600.0 мянган төгрөг нийт

376,378.8 мянган төгрөгийг санхүүжилтээр авч 295,934.5 мянган төгрөгийг зарцуулж 80,444.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Аймгийн онцгой байдлын газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01-А/519 тоот захирамжаар хотын доторх болон алслагдсан сум багийн автозамын хальтиргаа гулгааг арилгах бодис, давсны нөөц бүрдүүлэх 44,623.3 мянган төгрөгийн ажлын зардлыг дараа онд хэрэгжүүлэхээр санхүүгийн тайлан балансад Төрийн сангаас авах авлага үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Нийтийн орон сууц засвар	2024 он	Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ.	Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөр 3 дахь жилдээ хэрэгжиж байна. Иргэд идэвхтэй оролцож байна.	500,000.0	210,133.7
	Дүн				500,000.0	210,133.7

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Захирагчийн ажлын алба нь 2024 оны батлагдсан төсвийн дагуу худалдан авах ажиллагаагаар 21,430.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна. Үүнээс:

- Бичиг хэргийн зардалд 1,300.0 мянган төгрөг төлөвлөснөөс Хос Анар ХХК, Мон Өртөөчин ХХК-уудтай гэрээ байгуулан худалдан авалт хийсэн.
- Тээвэр шатахууны зардалд 5,477.5 мянган төгрөг, Шуудан холбоо, интернэтийн төлбөрт 5,470.0 мянган төгрөг төлөвлөж батлагдсан төсвийн дагуу худалдан авалтыг хийсэн байна.
- Тоног төхөөрөмжийн батлагдсан төсвөөс Хос-Анар ХХК-тай гэрээ хийж 2,954.8 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан байна.
- БСБ ХХК-тай гэрээ хийж 3,233,8 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан

болно. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн. Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 848,709.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16,974.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмж хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд:

1. Сул ажлын байрны 1 орон тооны цалин хөлс, НДШ-ийн зардлаас 12,100.3 мянган төгрөг
2. Хангамж, бараа материалын зардлаас 11.2 мянган төгрөг
3. Эд хогшил, урсгал засварын зардлаас 61,400.0 мянган төгрөг
4. Бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардлаас 40.1 мянган төгрөг тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан байгууллагын батлагдсан төсөв мэдээллийг 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулж байх зөвлөмж өгөх

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,644.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	6,644.0	4	6,644.0	100.0
Нийт дүн	4	6,644.0	4	6,644.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 116,222.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 114,382.8 мянган төгрөгийн алдааг залруулж 1,839.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон Үүнд:

- Засаг даргын 2024.12.27-ны 01-А/519 захирамжаар автозамын гулгаа халтиргааг арилгах давсны нөөц бүрдүүлэх 44,623.3 мянган төгрөгийн хийгдээгүй ажлыг тайлант үеийн зардлаар бүртгэсэнийг санхүүгийн тайлангийн авлагын дансанд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", санхүүгийн тайлангийн "Ангилал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулав.

- Тайлант үеийн санхүүгийн үр дүн 67,864.1 мянган төгрөгийн өмчийн өөрчлөлтийн тайланд тусгаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 3.4 дэх хэсэг, санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулсан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 1,895.4 мянган төгрөгийг өмчийн өөрчлөлтийн тайлан үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэлд дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 3.4 дэх хэсэг, санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулсан.

Мөн аудитаар нийт 1,839.7 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Засаг даргын тамгын газрын даргын 2024.08.12-ны өдрийн 2-10/1836 тоот албан бичгээр Захирагчийн ажлын албаны дарга Б.Оргилыг ажилд дуудан оруулахдаа 10 хоногийн цалин, ээлжийн амралтыг давхардуулан нийт 1,839.7 мянган төгрөг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитын тайлангаар зөвлөмж өгөөгүй.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Хийгдээгүй ажлыг тайлант үеийн зардлаар бүртгэснийг авлага үүсгэв	1	44623,3			1	44623,3	1	44623,3				

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тайлант оны санхүүгийн үр дүнг өмчийн өөрчлөлтийн тайланд тусгаагүй	1	67864,1			1	67864,1	1	67864,1				
өмчийн өөрчлөлтийн тайланг үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэлд дутуу тайлагнасан	1	1895,4				1895,4		1895,4				
Дүн	3	114382,8			3	114382,8	3	114382,8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин ээлжийн амралт давхардсан	1	1839,7	1	1839,7								
Дүн	1	1839,7	1	1839,7								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1 шийдвэр мэдээлээгүй байна.	1	6,188.6	-	-	-	-	1	6,188.6
Дүн	1	6,188.6	-	-	-	-	1	6,188.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	2	6,188.6	-	-	-	-	2	6,188.6



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/47-287200 82-2025/44/КА-СТА-ТМЗ. Дархан сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирагчийн ажлын албаны дарга Б.Оргилыг аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 2-10/1836 тоот албан бичгээр ажилд дуудан оруулахдаа 10 хоногийн цалин, ээлжийн амралтыг давхардуулан нийт 1,839,699.00 төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 1,839,699.00 (Нэг сая найман зуун гучин есөн мянга зургаан зуун ерэн есөн) төгрөгийг Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны дарга Б.Оргилоор төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Захирагчийн ажлын албаны дарга Б.Оргил, нягтлан бодогч Д.Энхтунгалаг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

"ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ
АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

С.ОРГИЛ

П.МАГСАРЖАЛАМ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



4525050200